

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2024.11.19 № 05/1784

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус яамнаас зарласан ЗТХЯ/20240103131 дугаартай “Хөнгөн төмөр замын тээвэр (LRT) төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (улаанбаатар)” боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга хүссэнтэй холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна.

	Оролцогчийн тодруулга	Тодруулгын хариу
1.	Тендерийн баримт бичигт дурдсан зураг төсөв гэдэг нь ажлын зураг төсөл болон төсөв гэж ойлгох уу, эсхүл техникийн буюу эдийн засгийн үндэслэлийн зураг, төсөв гэж ойлгох уу?	Хөнгөн төмөр замын тээвэр (LRT) төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар) боловсруулах ажлын даалгаврын 7.1-д “Толгойт-“Буянт-Ухаа”-Өлзийт-“Шинэ Зуунмод хот”-Зуунмод-Майдар-Налайх-Амгалан чиглэлийн техник, эдийн засгийн үндэслэл”, мөн даалгаврын 7.2-т “Толгойт-“Буянт-Ухаа”-Өлзийт-“Шинэ Зуунмод хот” чиглэлийн зураг төсөл”-ийг боловсруулах гэж заасан. “Толгойт-“Буянт-Ухаа”-Өлзийт-“Шинэ Зуунмод хот”-Зуунмод-Майдар-Налайх-Амгалан чиглэлийн техник, эдийн засгийн үндэслэл гэдэгт техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг, урьдчилсан төсвийг, “Толгойт-“Буянт-Ухаа”-Өлзийт-“Шинэ Зуунмод хот” чиглэлийн зураг төсөл гэдэгт Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг боловсруулна гэж ойлгоно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.